



ЖИЛИЙН ТАЙЛАН 2011



НИЙТЛЭГ ҮҮРЭГ

Монголын хөрөнгийн биржийн нийтлэг үүрэг нь брокер, диллер буюу арилжаанд оролцогч хуулийн этгээдүүдэд хувьцаа, бонд болон бусад төрлийн үнэт цаас арилжаалах нөхцлийг бүрдүүлэх, хувьцаат компаниуд үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл гүйлгээнд гаргах, татан авах мөн орлого болон ногдол ашиг хуваарилах зэрэг үйл ажиллагааг хянан зохицуулж, олон нийтэд мэдээлэл хүргэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахад оршино.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Монголын хөрөнгийн биржийн эрхэм зорилго нь санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн хуримтлалыг хямд өртөгтэйгээр урт хугацаанд зуучлан хүргэх үүрэг бүхий үнэт цаасны сонгодог зах зээлийг бий болгон төлөвшүүлэх замаар улс орны эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулахад оршино.

АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	4
МХБ-ийн 2011 оны товч статистик	5
Төлөөлөн удирдах зөвлөлийн танилцуулга	6
Байгууллагын бүтэц	7
"Ажлын мастер гэрээ"- ний дагуу хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулга	8
2011 оны үзүүлэлтүүд	
Үнэт цаасны бүртгэл	10
Үнэт цаасны арилжаа	11
ТОП-20 Индекс ба дэлхийн голлох индексүүд 2011 онд	13
Зах зээлийн үнэлгээ, анхдагч зах зээлийн арилжаа	14
Засгийн газрын болон компанийн бонд	15
Гишүүн компаниуд	16
МХБ-ийн сургалтын төв	17
2011 оны санхүүгийн үзүүлэлт	
Санхүүгийн тайлан	18
Орлогын тайлан	19

Мэндчилгээ



Эрхэм хүндэт хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид, мэргэжлийн болон зохицуулах байгууллагууд, үнэт цаасны зах зээл сонирхогч хамтран ажиллагч та бүхэнтэйгээ Монголын Хөрөнгийн Бирж болон Монголын үнэт цаасны зах зээлийн 2011 оны албан ёсны тайлангаар дамжуулан мэндчилж байгаад таатай байна.

2011 он бол Монгол улсын хувьд, ялангуяа хөрөнгийн зах зээлийн мэргэжилтэн бидний хувьд арвин их амжилтаар дүүрэн жил байлаа. Монголын хөрөнгийн зах зээлийг дэлхийн стандартад нийцүүлэх их ажлыг эхлүүлж Лондонгийн хөрөнгийн биржтэй стратегийн түншүүд боллоо. Энэ ажлыг санаачлан эхлүүлсэн Монгол Улсын Засгийн Газар, Ерөнхий сайд С.Батболд, алхам бүрт хамтран ажиллаж буй Төрийн Өмчийн Хороо, Санхүүгийн Зохицуулах Хороо, Лондонгийн Хөрөнгийн Бирж болон брокер дилер, андеррайтер зэрэг мэргэжлийн байгууллагын хамт олон та бүхэнд талархаж буйгаа илэрхийлье. Бид бүгдийн хамтын ажиллагааны үр дүнд Монголын хөрөнгийн зах зээл шинэ шатанд гарч иргэн бүр хувьцаа эзэмшигч болж компани бүр IPO хийн эх орныхоо хөгжил цэцэглэлтэнд бодит хувь нэмрээ оруулах гэрэлт ирээдүй бодит боломж болон хүрч ирээд байна.

2011 он бол бидний хувьд ололт амжилтаар дүүрэн жил байсан бөгөөд түүхэнд байгаагүй их үнийн дүн бүхий арилжаа хийлээ. Түүнчлэн сүүлийн хэдэн жилд зогсонги байдалд ороод байсан анхдагч зах зээлийн болон компанийн бондын арилжаа энэ онд мөн явагдсан амжилтаар бид өнгөрөгч оныг үдлээ.

Их хөгжил, их бүтээн байгуулалт, шинэчлэлийн төлөө хамтран ажиллаж буй нийт харилцагч хөрөнгө оруулагч, мэргэжлийн байгууллагууд, үнэт цаас гаргагчид та бүхэндээ аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.


Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал

A handwritten signature in blue ink, consisting of stylized cursive letters, likely representing the name Х.АЛТАЙ.

Х.АЛТАЙ

МХБ-ИЙН 2011 ОНЫ ТОВЧ СТАТИСТИК



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн дарга:

Б.Болд

“Гоулд Стрийм” ХХК-ийн гүйцэтгэх захирал. АНУ-ын Брижпортын их сургуулийн эдийн засгийн мастер. J.P.Morgan хөрөнгө оруулалтын банкны Лондон, Нью-Йорк, Токиогийн хөрөнгө оруулалтын банкны гүйцэтгэх захирал, дэд захирлаар ажиллаж байсан.

ТУЗ-ийн гишүүд:

Тони Вийрсинг

Лондонгийн хөрөнгийн бирж группын глобал хөгжлийн албаны захирал, Миллениум АйТи компанийн гүйцэтгэх захирал

Л.Ганбат

Төрийн өмчийн хорооны тамгын газрын дарга.

Антонелла Амадей

Лондонгийн хөрөнгийн бирж группын гадаад харилцааны албаны дарга

Штефан Ханзэлманн

ХБНГУ-ын GIZ байгууллагын Монгол Улс дахь зохицуулагч

Ө.Ганзориг

Монголын санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч.

О.Орхон

Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын орлогч


Н.Цогт

“Боналекс” ХХК-ийн өмгөөлөгч.

О.Сайнжаргал

Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн.

БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ЛОНДОНГИЙН ХӨРӨНГИЙН БИРЖТЭЙ БАЙГУУЛСАН "АЖЛЫН МАСТЕР ГЭРЭЭ"-НИЙ ДАГУУ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

2011 оны 04-р сарын 07-ны өдөр Монголын хөрөнгийн бирж /МХБ/ Лондонгийн хөрөнгийн бирж /ЛХБ/-тэй “Ажлын мастер гэрээ”-нд гарын үсэг зурсан билээ. Хоёр биржийн байгуулсан гэрээний дагуу Монголын хөрөнгийн зах зээлийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж шат дараалсан олон ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд эхний үр дүн гарч эхлээд байна. Уг гэрээнд зах зээлийг хөгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хууль, дүрэм, журмыг дахин боловсруулах, техник технологийг шинэчлэн дэлхийн жишигт хүргэх, боловсон хүчнийг чадавхижуулах, мэргэшсэн боловсон хүчин сургах, биржийн засаглал, зохион байгуулалтыг сайжруулан удирдах боловсон хүчнээр хангах зэрэг олон ажлууд хийгдэхээр тусгагдсан бөгөөд гэрээ нь гурван жилийн хугацаатай үргэлжлэх юм.

Зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр

МХБ болон ЛХБ хоорондын хамтын ажиллагааны үр дүнд зах зээлийн бүх оролцогчид, тэр дундаа хөрөнгө оруулагч болон үнэт цаас гаргагч компаниудын хувьд түүхэн чанартай дэвшил гарах юм. Одоогийн байдлаар манай зах зээлийн үнэлгээ дунджаар 2,2 их наяд (*манай улсын ДНБ-ний 20 гаруй хувьтай тэнцүү*) төгрөг байгаа бол 10 жилийн дотор 56-59 их наяд төгрөг хүртэл өсөх боломжтой юм.

Дотоодын тэргүүлэгч аж ахуйн нэгжүүд үнэт цаас гаргах тохиолдолд зах зээлийн үнэлгээ 5 орчин их наяд төгрөгөөр, стратегийн орд газар эзэмшигч 15 компани 17-23 их наяд, харин Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд нь 17-18 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй болох боломж харагдаж байна.

Эдгээр компаниудад зөвхөн дотоодын бус мөн гадаадын хөрөнгө оруулагчид идэвхитэй хөрөнгө оруулалт хийх нь дамжиггүй юм. Иймд дээрх оролцогч хооронд дэлхийн жишигт нийцсэн тогтолцоо бүхий, шуурхай, найдвартай, мэдээллийн хувьд ил тод байдлыг хангасан хууль эрх зүйн орчин байх шаардлагатай бөгөөд МХБ нь холбогдох байгууллагуудтай хамтран үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг шинэчлэх ажилд идэвхитэй оролцож, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулийн төслийг Засгийн газарт өргөн бариад байгаа билээ.

Зах зээлийн хөгжлийг тодорхойлогч нэг хүчин зүйл нь түүний хөрвөх чадвар байдаг. Хөрвөх чадвар сайн байх нь хөрөнгө оруулагчийн хувьд эрсдэлээс хамгаалах гол хэрэгсэл болдог. МХБ нь зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулахад чиглэсэн олон арга хэмжээг 2011 оны хоёрдугаар улирлаас эхлэн авч, бүртгэлтэй үнэт цаасны арилжааг А, В гэсэн хоёр самбарт хуваан явуулж эхэлсэн бөгөөд төлбөр тооцооны Т+3 тогтолцоог нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

МХБ-д бүртгэлтэй үнэт цааснуудын хөрвөх чадварыг нь дээшлүүлэх дараагийн шатны арга хэмжээний хүрээнд олон улсын томоохон индекс болох FTSE-г нутагшуулахаар ЛХБ-ийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллаж байна.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн индексийг нэвтрүүлснээр дотоодын аж ахуйн нэгжүүд өөрийн нэр хүндээ өсгөх, хямд өртгөөр хөрөнгө татах, томоохон институционал хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах, өөрийн үнэт цаасны хөрвөх чадварыг дээшлүүлэх зэрэг олон боломжийг олгох юм.

Эдгээр индексэд багтсан компаниудыг гадаадын томоохон банк санхүүгийн байгууллагуудын шинжээчид байнга ажиглаж байдаг бөгөөд дэлхийн томоохон мэдээллийн агентлагууд нь тус индекс болон түүнийг бүрдүүлж буй компаниудын тухай тогтмол мэдээллэж байдаг билээ.

Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр

МХБ нь ЛХБ-ийн тусламжтайгаар Монголын Хөрөнгийн зах зээлийн Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажилд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж байна. Биржийн зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт оролцож олон улсын хуульчид, ЛХБ, Дэлхийн банк, биржийн гишүүд болон бусад мэргэжилтнүүдээс санал, зөвлөмж авсаны үр дүнд хуулийн төслийг эцсийн байдлаар боловсруулж 2011 оны 09 сарын 01-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн билээ. Уг хуулийн төсөлд Монголын хөрөнгийн зах зээлийн дэлхийн хэмжээнд хүргэх бүхий л эрх зүйн зохицуулалтыг тусгасан юм.

Зах зээлийн үйл ажиллагааг өндөр бүтээмж, эмх цэгцтэй, ил тод байлгахад шаардлагатай цогц дүрэм, журмыг Лондонгийн хөрөнгийн биржийн мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулсан бөгөөд одоогийн байдлаар Арилжааны болон Гишүүнчлэлийн журам батлагдан мөрдөгдөж эхлээд байна. Мөн Бүртгэлийн, Үнэт цаасны танилцуулгын болон Мэдээллийн нээлттэй, ил тод байдлын журмуудыг хэлэлцэж байна.

Millennium IT систем—техник, технологийн шинэчлэл

Millennium IT цогц арилжааны систем нь дөрвөн үндсэн программ буюу Millennium Exchange, Millennium CSD, Millennium Surveillance, Millennium Trader гэсэн хэсгүүдээс бүрдэх ба Лондонгийн хөрөнгийн биржийн охин компани болох MIT компанийн бүтээгдэхүүн юм.

Дэлхийн хөгжингүй улс орнууд бүгд бүрэн интеграцлагдсан арилжаа, төлбөр тооцоо, хадгаламж, хяналтын системтэй байдаг ба Millennium IT цогц системийн шийдэл нь зөвхөн Монголын хөрөнгийн бирж бус брокер дилерийн компаниуд, төлбөр тооцоо хадгаламжийн төв, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг зах зээлийн оролцогч, зохицуулагч байгууллагуудын системийн шинэчлэлд хамруулж буй хөрөнгө оруулалт гэж ойлгож болно.

Тус систем нь мэдээлэл дамжуулах өндөр хурд, багтаамж, хэрэгцээнд тохируулан өргөтгөн өөрчлөх боломжтой, гар ажиллагааг багасгаж, олон төрлийн мэдээллийг цэгцлэн боловсруулан гадны мэдээллийн агентлагуудад чөлөөтэй мэдээллэх, арилжаанд онлайн болон албан тасалгаанаасаа шууд оролцох зэрэг олон давуу талыг хэрэглэгчиддээ олгох юм.

Энэхүү технологийн шинэчлэлийн төслийн хүрээнд Шри-Ланка улсын Millennium IT компаниас Millennium IT системийг суулгахад шаардлагатай дэд бүтцийг шийдлүүдийг суурилуулах мэргэжилтнүүд ирж ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд Millennium IT компаниас олон чиглэлийн 6 мэргэжлийн баг ирж ажилласан бөгөөд шинэ системийг МХБ-ийн мэдээллийн технологийн мэргэжилтнүүдтэй хамтран 2012 оны эхний улиралд нэвтрүүлж зорилготой ажиллаж байгаа билээ.

Сургалт - Салбарын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх чиглэлээр

Ажлын Мастер гэрээний дагуу Хөрөнгийн зах зээлийн дунд болон гүнзгийрүүлсэн шатны мэдлэг олгох сургалтууд Лондонгийн хөрөнгийн биржийн академийн мэргэжилтэн багш нарын удирдлаган доор Улаанбаатар болон Лондон хотуудад 2011 оны 6-р сарын 13-ны өдрөөс 9-р сарын 10-ны хооронд амжилттай явагдсан билээ.

Уг сургалтанд Монголын хөрөнгө, санхүүгийн зах зээлийн төлөөлөл болох Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо, брокерийн пүүсүүд, арилжааны банкууд, Төрийн өмчийн хороо, Монгол банк, Сангийн яам, Хууль Зүй Дотоод Хэргийн Яам, Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэргэжилтэн, албан хаагчид хамрагдсан байна.

Улаанбаатар хот дахь сургалт нь нийт 60 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2011 оны 6-р сарын 13 өдрөөс 7-р сарын 21-ний хооронд, Лондон хот дахь сургалт 2011 оны 8-р сарын 23-ны өдрөөс 9-р сарын 10-ны хооронд зохион байгуулагдаж 49 хүн оролцсон.

Сургалтын хөтөлбөрийн дагуу оролцогчид Лондонгийн хөрөнгийн бирж, металлын бирж, дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын банкууд болох UBS болон Goldman Sachs-ийн үйл ажиллагаатай танилцаж компаниудын удирдах албан тушаалтнуудтай уулзсан юм.

Мөн зах зээлд оролцогчдын мэргэшлийг дээшлүүлэх сургалт байнга явагдаж байна.

Эдгээр сургалтуудыг дурьдвал:

- Брокер дилерийн компаниудын мэргэжилтнүүдийг шинээр суурилуулж буй Millennium IT системийн үйл ажиллагаанд дадлагажуулах сургалт явагдаж байна.

- Санхүүгийн зохицуулах хороо, Монгол банкны болон МХБ-ийн ажилчдыг Millennium IT системийн нэг хэсэг болох Millennium Surveillance арилжаа хяналтын системд дадлагажуулах сургалтыг Millennium IT компанийн багш нар зааж байна.

- Millennium IT системийн бас нэг хэсэг болох Millennium Depository системийн сургалтыг Millennium IT-ийн багш нарын удирдлага дор Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвийн ажилчдад зориулан явуулсан билээ.

- Millennium Exchange системийн сургалтыг МХБ-ийн ажилчдад зориулан Millennium IT-ийн багш нартай хамтран зохион байгууллаа.

- Монголын Хөрөнгийн Бирж болон Үнэт Цаасны Төлбөр Тооцоо Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн хамтран зохион байгуулсан Монголын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэх гэж буй олон улсын туршлага, зах зээлийн зохицуулалт болон зах зээлийн бүтцэд хийгдэх өөрчлөлтүүдийн талаар танилцуулах семинар 2011 оны 10-р сарын 28-ны өдөр болсон билээ.

Бүтэц, зохион байгуулалт

МХБ-ийн хамтарсан удирдлагын багийн зүгээс биржийн бүтцийг оновчтой болгож, олон улсын жишгийн дагуу шинэчлэн баталсан. МХБ-ийн ТУЗ-ийн гишүүдийн тухай мэдээллийг 6 дугаар нүүрээс, шинэ бүтцийн тухай 7 дугаар нүүрээс харна уу.

Туршлагатай боловсон хүчин

Ажлын мастер гэрээний хүрээнд ЛХБ-ийн зүгээс МХБ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, харилцан туршлага солилцох зорилгоор үнэт цаасны зах зээлд олон жил ажилласан туршлагатай боловсон хүчээ Монголд ажилуулж байна.

Дамита Күүк - Ерөнхийлөгч бөгөөд Үйл ажиллагаа, мэдээллийн технологи хариуцсан дэд захирал,

Жүрген Зеүсс - Төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

2011 он нь үнэт цаасны зах зээлээс хөрөнгө мөнгө босгох сонирхол, хандлага сэргэж идэвхижсэн жил байлаа.

Монголын хөрөнгийн биржид 2011 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт 332 ХК бүртгэлтэй байгаагаас 6.9% буюу 23 ХК нь 100 хувь төрийн өмчит, 8.7% буюу 29 ХК нь төрийн өмчийн оролцоотой, 84.3% буюу 280 ХК нь бүрэн хувьчлагдсан компани байна. Харин бүртгэлтэй үнэт цаасны хувьд нийт 2.8 тэрбум ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас 67.5% буюу 1.9 тэрбум ширхэг нь төрийн мэдлийн, 32.5% буюу 0.9 сая ширхэг нь хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувьцаа байна.

Тайлант хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-ийн хувьцааг шинээр, “Шарын гол” ХК болон “Силикат” ХК-ийн нэмэлт хувьцааг бүртгэх шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу хийж үнэт цаасыг бүртгэн аваад байна.

Мөн “Сөдөт” ХК, “УСИБ” ХК, “Мөнх-Үндэс” ХК, “Монгол шевро” ХК, “Дархан гурил гэжээл” ХК зэрэг нийт 5 компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, “Хаш Өргөө” ХК, “Монгол ном” ХК, “Орд харш” ХК, “Чандмань тал” ХК, “Жол” ХК-иудыг бүртгэлээс хасах ажиллааг хийж гүйцэтгэсэн байна.

Бүртгэлтэй үнэт цаасны тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад үнэт цаасны тоо ширхэг нь өмнөх оноос 99.9 сая ширхгээр буюу 4 орчим хувиар өссөн бол бүртгэлтэй ХК-ийн тоо 4 нэгжээр буурч, үнэт цаасны шалгуур хангахгүй компаниудын тоо цөөрсөөр байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2010 он	2011 он	ӨӨРЧЛӨЛТ
Бүртгэлтэй компанийн тоо	336	332	-4
Төрийн өмчит	51	52	1
Хувийн өмчийн	285	280	-5
Бүртгэлтэй үнэт цаасны тоо /сая ширхэг /	2,685.6	2,785.5	99.8
Төрийн өмчид /сая ширхэг /	1,854.4	1,881.2	26.8
Хувийн өмчийн /сая ширхэг /	831.2	904.3	73.7
Үнэт цаас шинээр бүртгүүлсэн ХК	-	1	1
Төрийн өмчит ХК	-	1	1
Хувийн өмчийн	-	-	-
Шинээр бүртгүүлсэн үнэт цаасны тоо (“Монголын Төмөр Зам” ТӨХК) /ширхэг/	-	226,000	226,000
Нэмж үнэт цаас гаргасан ХК	2	3	1
Нэмж бүртгүүлсэн үнэт цаасны тоо /сая ширхэг/	3.8	19.2	15.4
Бүртгэлээс хасагдсан ХК	22	5	-17
Хасагдсан үнэт цаасны тоо /сая ширхэг/	259.4	1.0	
Хувь нийлүүлэгчдийн хурал зарласан ХК	159	155	-4
Ногдол ашиг тараасан ХК	16	28	12
Баланс ирүүлсэн ХК	151	158	7

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2011 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаагаар 148 компанийн 122.8 сая ширхэг хувьцааг 109.1 тэрбум төгрөгөөр, 2.4 сая ширхэг Засгийн газрын энгийн бондыг 236.7 тэрбум төгрөгөөр, 439.5 мянган ширхэг компанийн бондыг 4.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 350.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 125.6 сая ширхэг үнэт цаас арилжсан байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 31.2 хувь буюу 109.1 тэрбум төгрөгийг хувьцааны

гүйлгээний дүн, 67.6 хувь буюу 236.7 тэрбум төгрөгийг Засгийн газрын бондын арилжааны гүйлгээний дүн, 1.2 хувь буюу 4.4 тэрбум төгрөгийг компанийн бондын гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

Нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал арилжааны үнийн дүн 257.4 тэрбум төгрөгөөр буюу 3.8 дахин өссөн үзүүлэлттэй байна.

ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	2009 он	2010 он	2011 он
Арилжаа явагдсан өдөр	өдөр	255	253	252
Үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн тоо	ширхэг	358	336	332
Зах зээлийн нийт үнэлгээ	тэрбум төгрөг	620.71	1,373.9	2,168.57
Үнэт цаасны гүйлгээний дүн	тэрбум төгрөг	23.18	92.87	350.24
Компанийн хувьцаа	тэрбум төгрөг	23.18	62.87	109.11
Засгийн газрын бонд	тэрбум төгрөг	-	30.00	236.73
Компанийн бонд	тэрбум төгрөг	-	-	4.39
Арилжигдсан үнэт цаасны тоо	сая ширхэг	89.92	64.52	125.59
Компанийн хувьцаа	сая ширхэг	89.92	64.51	122.78
Засгийн газрын бонд	сая ширхэг	-	0.00	2.37
Компанийн бонд	сая ширхэг	-	-	0.44
Өдрийн дундаж гүйлгээ				
Компанийн хувьцаа	сая ширхэг	90.91	248.51	432.98
Засгийн газрын бонд	сая ширхэг		0.25	16,909.33
Компанийн бонд	сая ширхэг	-	-	313.90
ТОП-20 индекс				
Дундаж	нэгж	5551.93	10582.80	21 420,81
Хамгийн их	нэгж	7937.13	15039.97	32 954,97
Хамгийн бага	нэгж	4537.98	6144.28	14 686,64
Хаалт	нэгж	6189.91	14759.81	21 687,57
Үнэт цаас эзэмшигчдийн дансны тоо		443 290	453 681	564 550
Аж ахуйн нэгж байгууллага		725	794	1 519
Хувь хүн		442 565	452 887	563 031
Брокер, дилерийн компанийн тоо		45	45	76

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

2010 онд өдөрт дунджаар 255.0 мянган ширхэг хувьцаа арилжиж, 248.5 сая төгрөгийн гүйлгээ хийж байсан бол 2011 онд өдрийн дундаж үзүүлэлт нь 487.2 мянган ширхэг, үнийн дүнгээр 432.9 сая төгрөг болж өссөн байна.

Тайлант хугацаанд ханш нь өссөн үнэт цааснуудыг тэргүүлж Азия пасифик пропертис ХК (28 010.2%), Дархан тээвэр ХК (13 013.8%), Тав ХК (10 916.9%), Ар баянхангай ХК (3 221.0%), Бэрх уул ХК (2 446.7%) зэрэг компаниудын үнэт цаас орж байна. Тоо ширхгээр идэвхитэй арилжигдсан үнэт цаасанд “Ремикон” /33.3 сая ширхэг/, “Термес центр” / 26.0 сая ширхэг/, “Силикат” / 17.8 сая ширхэг/, “Бэрх уул” /10.2 сая ширхэг/, “Женко тур бюро” /5.6 сая ширхэг/ зэрэг ХК-иудын үнэт цаас орж байна.

Арилжигдсан үнийн дүнгээр “Шарын гол” /51.7 тэрбум төгрөг/, “Багануур” /10.1 тэрбум төгрөг/, “АПУ” /7.6 тэрбум төгрөг/, “Таван толгой” /4.7 тэрбум төгрөг/, “Ремикон” /4.5 тэрбум төгрөг/ зэрэг ХК-иудын үнэт цаас идэвхитэй арилжигдсан байна.

Тайлант хугацаанд 148 компанийн үнэт цаас арилжигдсанаас 129 компанийн үнэт цаасны ханш өсч, 13 компанийн үнэт цаасны ханш буурч, 6 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа.

Ханшийн хамгийн өндөр өсөлттэй

#	Компанийн нэр	өссөн хувь	#	Компанийн нэр	өссөн хувь
1	Азия пасифик пропертэйс	28 010,2	16	Хасу мандал	843,6
2	Дархан тээвэр	13 013,8	17	Ган хийц	823,1
3	Тав	10 916,9	18	Баян алдар	762,4
4	Ар-Баянхангай	3 221,0	19	Баялаг налайх	700,0
5	Бэрх уул	2 446,7	20	Алмаас	617,7
6	Хэрэглээ импэкс	2 148,3	21	Монгол мах экспо	590,0
7	УСИБ	2 013,5	22	УБ БҮК	584,2
8	Их барилга	1 650,0	23	Монгол керамик	571,9
9	Монгео	1 512,9	24	Дархан ЗБ	555,2
10	Хөсөг трейд	1 338,5	25	Хөвсгөл алтандуулга	517,3
11	Хишиг Уул	1 333,3	26	Бөхөг	513,4
12	Эрдэнэт суврага	1 288,0	27	Агротехимпекс	492,4
13	Сав шим	956,8	28	Дархан хөвөн	490,6
14	Харшийн гэгээ	947,0	29	Чацаргана	430,1
15	Ундрага Өмнөговь	878,3	30	Ган хэрлэн	429,3


ТОП-20 Индекс ба дэлхийн голлох индексүүд 2011 онд

ТОП-20 Индекс 2011 онд

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 32954.97 нэгж, доод үзүүлэлт 14686.64 нэгж, дундаж үзүүлэлт 21420.81 нэгж байна. 2011 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6927.76 нэгжээр буюу 46.9 хувиар өсч 21687.57

нэгж болсон байна.

ТОП-20 индекс болон дэлхийн голлох 8 индексийн 2011 оны үзүүлэлтийг доорх инфографикаас харна уу.



ТОП-20 индекс оны эхнээс тогтвортой өсч, 02 дугаар сарын 25-ны өдөр 32954.97 нэгжид хүрсэн нь хөрөнгийн зах зээлийн түүхэн дэх хамгийн дээд үзүүлэлт байлаа.

Ийнхүү ТОП-20 индексийг өсөхөд индексийн сагсанд багтдаг Баянтээг /414.2%/,

Сүү /209.7%/, Талх чихэр /183.8%/, Могойн гол /162.7%/, Ремикон /144.4%/, АПУ /111.1%/, Таван толгой /91%/, Монгол шилтгээн /60.5%/, Баянгол ЗБ /50.4%/ зэрэг ХК-иудын үнэт цаасны ханшийн өсөлт голлон нөлөөлжээ.

ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

Зах зээлийн үнэлгээ

Зах зээлийн нийт үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 794.6 тэрбум төгрөгөөр буюу 57.8 хувиар өсч, 2 их наяд 168.6 тэрбум төгрөг болсон байна. Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй компанид Таван толгой ХК /579.3 тэрбум/, АПУ ХК /312 тэрбум/, Багануур ХК /274.8 тэрбум/, Шивээ овоо ХК /205.3 тэрбум/, Шарын гол ХК /96.7 тэрбум/ зэрэг хувьцаат компаниуд орж байна.

2011 оны 2 дугаар сарын 25-ны өдөр хөрөнгийн зах зээлийн үнэлгээ Монгол улсын ДНБ (10 их наяд 829,6 тэрбум төгрөг - 2011 оны үзүүлэлт /ҮСХороо) -ний 32,8 хувьд хүрсэн байна.

Харин жилийн эцсийн байдлаар 20%-тай байлаа.

Өнгөрөгч оны эцсийн байдлаар бүртгэлтэй компани бүрийн зах зээлийн үнэлгээг авч үзэхэд уул уурхайн салбарын компаниуд нийт зах зээлийн үнэлгээний 60%-ийг, Аж үйлдвэрийн салбар 22%-ийг, Худалдаа үйлчилгээний салбар 14%-ийг, Барилга тээврийн салбар 3%-ийг, Хөдөө аж ахуйн салбар 1%-ийг тус тус эзэлж байна.

Зах зээлийн үнэлгээ ба түүний 2011 оны ДНБ-д эзлэх хувь



Анхдагч зах зээлийн арилжаа

Анхдагч зах зээлийн арилжаагаар “Шарын гол” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 11,117 төгрөгийн үнэтэй 1,6 сая ширхэг хувьцааг 18,301.4 сая төгрөгөөр, “Силикат” ХК-ийн нэмж гаргасан нэг бүр нь 225

төгрөгийн үнэтэй 16.2 сая ширхэг хувьцааг 3,650,0 сая төгрөгөөр тус тус арилжсан нь анхдагч зах зээл дээрх нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 20.1 хувийг эзэлж байна

ЗГ-ЫН БОЛОН КОМПАНИЙН БОНД

Засгийн газрын бондын арилжаа

2011 онд Засгийн газрын бондын арилжаа 14 удаа явагдаж, “4000 төрийн албан хаагчдыг орон сууцны урт хугацаат зээлд хамруулах” хөтөлбөрийн санхүүжилтэд 65.0 тэрбум төгрөгийн бонд, ноос ноолуурын болон жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтэд 171.7 тэрбум төгрөгийн бонд арилжиж, нийт 236.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 2.4 сая ширхэг бондыг арилжлаа.



ЗГ-ын бонд худалдан авагчдын задаргаа

Компанийн бондын арилжаа

“Жаст агро” компанийн гаргасан нэг бүр нь 10.0 мянган төгрөгийн үнэтэй 3.0 сая ширхэг, нийт 30.0 тэрбум төгрөгийн “Монгол мах” бондын эхний 10.0 тэрбум төгрөгийн бонд энэ оны 9 дүгээр сараас арилжаалагдаж эхэлсэн бөгөөд нийт 439.5 мянган ширхэг бондыг 4.4 тэрбум төгрөгөөр арилжаалагдаад байна.



2011 онд арилжигдсан үнэт цаасны үнийн дүн

2011 онд хийгдсэн арилжааны хэмжээг өмнөх оны жилийн эцэстэй харьцуулахад

Үнэт цаасны нэр	Арилжааны үнийн дүн		Өөрчлөлт	
	2010 онд	2011 онд	Үнийн дүнгээр	Хувиар
ЗГ-ын бонд	30.0	236.7	206.7	+ 690%
Хувьцаа (үнийн дүн тэрбум төгрөгөөр)	62.9	109.1	46.2	+73.4%
Хувьцаа (тоо ширхэг сая)	64.5	122.8	58.3	+90.4%
Компанийн бонд (үнийн дүн тэр бум төгрөгөөр)	-	4.4		
Компанийн бонд (тоо ширхэг мянга)		439.5		

ГИШҮҮН КОМПАНИУД

Өнгөрсөн онд нийт 31 компани МХБ-ийн гишүүнээр элсэж, 2011 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт 76 гишүүн компанид 540 гаруй ажилтан бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 76 компанийн 23 нь

андеррайтерийн, 15 нь хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх эрхтэй байна.

2011 онд хамгийн идэвхитэй 27 гишүүн компаниудын гүйцэтгэсэн арилжааны үнийн дүн, сая төгрөгөөр

#	Код	Гишүүн компани	Хувьцааны арилжаа	Бондын арилжаа	Нийт
1	7	"Би ди сек" ХК	148,302.36	84,384.94	232,687.30
2	71	"Ти ди би капитал" ХХК	70.61	105,766.00	105,836.61
3	18	"Монсек" ХХК	3,308.05	23,424.20	26,732.25
4	77	"Капитал маркет корпораци" ХХК	1,546.63	16,570.00	18,116.63
5	57	"Ард капитал групп" ХХК	1,679.67	11,858.20	13,537.87
6	31	"Гендекс" ХХК	6,372.55	-	6,372.55
7	62	"Евразиа капитал монголиа" ХХК	5,847.99	453.50	6,301.49
8	59	"Гаули" ХХК	5,610.66	-	5,610.66
9	48	"Фронтнер" ХХК	4,883.88	10.00	4,893.88
10	29	"Дэлгэрхангай секьюритиз" ХХК	3,777.23	-	3,777.23
11	22	"Азиа пасифик секьюритис" ХХК	3,117.46	13.86	3,131.32
12	108	"Би би эс эс" ХХК	42.24	3,000.00	3,042.24
13	63	"Финанс линк групп" ХХК	2,707.88	-	2,707.88
14	76	"Ай трейд" ХХК	2,421.65	-	2,421.65
15	47	"Нэйшнл секьюритис" ХХК	2,273.29	-	2,273.29
16	13	"Булган брокер" ХХК	2,208.45	-	2,208.45
17	32	"Монет" ХХК	2,069.34	28.36	2,097.70
18	65	"Монхан трейд" ХХК	1,629.39	-	1,629.39
19	69	"Эм даблью ти эс" ХХК	1,513.81	0.12	1,513.93
20	45	"Батс" ХХК	1,415.64	-	1,415.64
21	70	"Рескап секьюритис" ХХК	1,414.24	-	1,414.24
22	15	"Дархан брокер" ХХК	1,323.13	-	1,323.13
23	5	"Зэргэд" ХХК	1,289.08	0.80	1,289.88
24	51	"Эт ай си си" ХХК	1,118.37	-	1,118.37
25	25	"Таван богд" ХХК	972.58	-	972.58
26	49	"Блюмсбюри секьюритис" ХХК	876.27	-	876.27
27	19	"Тулгат чандмань баян" ХХК	827.07	7.20	834.27
		Бусад	9,602.08	2.50	9,604.58
		Нийт	218,221.62	245,519.68	463,741.30

МХБ-ИЙН СУРГАЛТЫН ТӨВ

Хөрөнгийн зах зээлд ажиллах мэргэжлийн боловсон хүчний эрэлт, хэрэгцээг хангах, сонирхсон иргэд, оюутан, сурагчдад үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох байнгын болон цаг үеийн асуудлаар сургалт, семинари зохион байгуулах зорилгоор 2005 оны 10 сарын 31-ний өдөр МХБ-ийн Хэрэг Эрхлэх Газрын харьяанд “Хөрөнгийн зах зээлийн сургалтын төв”-ийг байгуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар 3000 гаруй иргэдийг (байгууллага, хамт олны захиалгыг оруулан) сургалтанд хамруулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Сургалтын төв нь байнгын үйл ажиллагаа явуулах ба багшлах боловсон хүчний хувьд санхүүгийн зах зээлд ажиллаж буй Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон бусад мэргэжлийн байгууллагуудын удирдлагууд, туршлагатай ажилтан, мэргэжилтнүүд болон их, дээд сургуулийн багш нар хичээл заадаг.

Сургалт нь онол практикийг хосолсон байх ба хөрөнгийн зах зээлийн үндсэн ойлголтууд, эрх зүйн зохицуулалт, зах зээлд оролцогч байгууллагуудын үйл ажиллагаа болон практик дадлага туршлага олгох хичээлүүд орох ба сургалт бүрийн онцлогт тохирсон давтлага хичээл ордог давуу талтай.


Сургалт явагдаж дуусах бүрт Комисс шалгалт авч, амжилттай төгсөгчдөд сертификат олгодог.

Сургалтын төвөөс “Үнэт цаасны зах зээлийн суурь мэдлэг олгох сургалт”, “Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн курс”, “Мэргэжил дээшлүүлэх курс”, Үнэт цаас гаргагчдад зориулсан сургалт зэрэг сургалт, курсуудыг тухай бүр олон нийтэд зарлан элсэлт авч хичээллүүлж байна. Мөн байгууллага хамт олны захиалгаар Үнэт цаасны зах зээлийн талаар сургалт явуулдаг.

Монгол Улсын засгийн газраас хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж буй өнөө үед сургалтын эрэлт хэрэгцээ өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж, иргэд хувь хүмүүс олноор хандах болсон. Мөн түүнчлэн хөдөө орон нутаг болон гадаадад сууж буй монгол иргэдээс манай сургалтанд хамрагдах хүсэл байсан ч өөрийн биеэр ирж суух боломж бага байгаа тул хөдөө орон нутгийнханд зориулан сургалт зохион байгуулахыг хүссэн санал олноор ирж байна.

Мөн байгууллага хамт олны захиалгаар нийт 1500 гаруй иргэдийг хамруулсан байна.

Сүүлийн 7 жилд сургалтанд хамрагдсан иргэдийн тоо



САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2011 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар
болсон жилийн санхүүгийн тайлан

Мянган төгрөг

Хөрөнгө	2009	2010	2011
Бэлэн мөнгө	138 548,75	335 800,91	2 268 151,92
Дансны авлага	18 256,48	17 605,81	35 762,68
Бараа материал	67 990,32	79 777,85	87 174,00
Бусад эргэлтийн хөрөнгө	238 673,80	186 791,30	3 953 079,65
Эргэлтийн хөрөнгийн дүн	463 469,36	619 975,86	6 344 168,25
Эргэлтийн бус хөрөнгө	2 378 753,21	2 362 135,33	3 923 540,67
Нийт хуримтлагдсан элэгдэл	(243 234,39)	(530 992,51)	(620 811,81)
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2 135 518,82	1 831 142,82	3 302 728,86
Хөрөнгийн нийт дүн	2 598 988,18	2 451 118,68	9 646 897,12
Өр төлбөр			
Дансны өглөг	728.59	760.91	672,186.86
Ногдол ашгийн өглөг			
Өрийн бичгийн өглөг			
Бусад өглөг	2,248.40	5,258.50	1,562,885.31
Өр төлбөрийн нийт дүн	2,977.00	6,019.41	2,235,072.18
Эзэмшигчдийн өмч			
Өмч	1,867,708.80	1,867,708.80	1,867,708.80
Хуримтлагдсан ашиг			
тайлангийн үеийн	(173 768,05)	23 207,01	463 509,32
өмнөх үеийн	813 214,12	528 460,20	548 186,21
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	88,856.32	25,723.26	4,532,420.60
Эзэмшигчдийн өмчийн дүн	2,596,011.19	2,445,099.27	7,411,824.94
Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн нийт дүн	2,598,988.18	2,451,118.68	9,646,897.12

ОРЛОГЫН ТАЙЛАН

2011 оны 12 дугаар сарын 31-ний өдөр
дуусгавар болсон жилийн орлогын тайлан

Орлого	Мянган төгрөг		
	2009	2010	2011
Үнэт цаасны арилжааны шимтгэл	176 294,74	463 699,85	800 630,03
Хураамж:			
Бүртгэл, гишүүд, судалгаа	104 861,67	75 244,07	92 239,58
Бусад орлого	89 692,12	102 331,28	1 988 109,90
Нийт орлого	370,848.53	641,275.20	2,880,979.51
Зардал			
Цалин, нийгмийн даатгалын шимтгэл	211,895.48	223,409.61	409,344.58
Ашиглалтын зардал	20,272.74	13,600.78	14,975.65
Албан томилолтын зардал, ТУЗ болон удирдлагын зардал	39,353.98	29,951.27	33,958.22
Унаа, шатахуун, засварын зардал	13,739.27	26,290.60	57,478.13
Түүхий эдийн зардал	15,970.94	35,426.12	23,149.93
Элэгдлийн зардал	98,054.91	113,848.70	123,062.79
Зар сурталчилгаа, сургалтын зардал	21,954.06	21,514.54	56,078.19
Шуудан холбооны зардал	12,239.61	26,165.68	39,995.29
Бусад зардал	94,812.53	121,990.08	1,545,154.40
Нийт зардал	528,293.54	612,197.39	2,303,197.19
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(157,445.01)	29,077.81	577,782.32
Үндсэн бус үйлдвэрлэл, үйлчилгээний ашиг (алдагдал)	(17,053.94)	(2,079.26)	(70,135.89)
Валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн ашиг (алдагдал)	730.90	(1,212.98)	(16,080.75)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(16,323.04)	(3,292.24)	(86,216.64)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(173,768.05)	25,785.57	491,565.68
Орлогын татварын зардал		2,578.56	28,056.36
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(173,768.05)	23,207.01	463,509.32



London
Stock Exchange

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монголын хөрөнгийн бирж

Хаяг: Сүхбаатарын талбай-2, Улаанбаатар, Монгол улс

Факс: (+976)-11-325170

Website: www.mse.mn

E-mail: info@mse.mn

By Bat - Orgil N.
Senior specialist
Primary Market Development
Mongolian Stock Exchange